



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 10/64

Бодь

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны
төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж
үнэлгээ өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 48.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3, 64.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхийг сумын Засаг дарга (Р.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.АМАР-АМГАЛАН



648801020